

**ООСОРЛОГЧ, ДОХИОЧНЫ ЭРХ ОЛГОХ СУРГАЛТЫН  
АЖЛЫН ДААЛГАВАР**

№	АГУУЛГА	
1	Зорилго	Салбарын үйл ажиллагаанд өргөх, зөөх төхөөрөмж, түүний аюулгүй ажиллагаа, оосорлох хэрэгслийн талаар ажил, үүргээ гүйцэтгэхэд ажилтныг мэргэшүүлж, эрх олгоно.
2	Зорилт	Сургалтын хэрэгцээнд үндэслэн чанартай, үр дүнтэй сургалтыг зохион байгуулах.
3	Хэрэгцээ, шаардлага	Компанийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг Олон Улсын шаардлагын дагуу гүйцэтгэж, ажлын бүтээмжийг тасралтгүй сайжруулж ажиллах.
4	Сэдэв	<p>Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Кран, өргөх төхөөрөмжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал</li> <li>• Кран, өргөх төхөөрөмжийн ерөнхий бүтэц, ажиллах зарчим, ангилал</li> <li>• Кран, өргөх төхөөрөмжийн эд ангиудын бүтэц, онцлог</li> <li>• Орчин үеийн кран, өргөх төхөөрөмжийн онцлог</li> <li>• Ерөнхий ходолмор хамгаалал</li> <li>• Кран, өргөх тохоромжийг тохөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрмийн ерөнхий агуулга</li> <li>• Кран, өргөх төхөөрөмжийг ашиглахад оролцдог субъектийн ажиллах журам</li> <li>• Ачаа өргөх, шилжүүлэх үед гараар өгөх дохионы төрөл, хэлбэр, хэрэглээ</li> <li>• Ачааг баглаж, оосорлох, өрж хураах журам</li> <li>• Хөдөлмөр хамгаалал, ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа</li> <li>• Ачаа оосорлох хэрэгсэл, дэгээ, тэнжээ, ган татлага, ган татлага голлолдолд гаргах гэх мэт</li> </ul>
5	Хэлбэр	Онол болон практик хосолсон байдлаар
6	Тавигдах шаардлага	<p><u>Сургалтын байгууллагад:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх;</li> <li>• Тухайн чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай;</li> <li>• Сүүлийн 3 ба түүнээс дээш жил уул уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай;</li> <li>• Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалтыг явуулах;</li> <li>• Сургалтын өөрийн анги, танхим, техник, тоног төхөөрөмжтэй байх;</li> <li>• Сургалтыг хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах;</li> <li>• Тухай сургалтын агуулга, хугацаа, хамрах хүрээ зэргээс шалтгаалан мэргэжлийн багш нартай байх;</li> <li>• Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх олгох.</li> </ul>

		<u>Сургагч багшид:</u> <ul style="list-style-type: none"> <li>• Сургагч багш нь тухайн чиглэлийн мэргэжлийн бөгөөд мэргэшсэн байх;</li> <li>• Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;</li> <li>• Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх;</li> <li>• Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах.</li> </ul>
7	Хамрах хүрээ	23 ажилтан /ГАЗМХэлтэс/
8	Хугацаа	2021 оны 2-3 дугаар улиралд 24 академик цаг /сургалтын агуулгаас шалтгаалан сургалтын цагийг нэмж, хасах боломжтой/ “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давтамжтай явуулах
9	Төсөв	Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн болон бусад зардал
10	Байршил	Улаанбаатар хотод
11	Үр дүн	Сургалтад хамрагдсан ажилтны мэдлэг, ур чадвар нэмэгдэж, ажлын бүтээмж өснө.

ХЯНАСАН:  
СУРГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА  
Огноо: 2021.08.25



Н.ЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН:  
СУРГАЛТЫН АЛБАНЫ  
МЭРГЭЖИЛТЭН  
Огноо: 2021.08.25



Н.САРАНТУЯА